



ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН АЖИЛ

“МЕРЕКС” ХК-ИЙН

2025 оны 12 сарын 31-ний өдрийн санхүүгийн дуусвар тайлан

2026 он



“МЕРЕКС” ХК-ИЙН ТУЗ-ЫН ДАРГА
БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НАРТ

ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

15171 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бахула Ринбүүчийн гудамж, Оршил-2 төв, 5 давхар,
Утас: 9908 5151, 9199 1482, Факс: (976-11) 32 52 62,
И-мэйл: byambaahunnu@yahoo.com, Вэб: www.dumaudit.mn

2026.04.06 № 83

танай _____-ны № _____-т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д заасны дагуу Мерекс ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмч өөрчлөлтийн тайлангийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус ба аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжүүд хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал:

- Улсын бүртгэлийн гэрчилгээнд компанийн дүрэм, гүйцэтгэх удирдлага болон эцсийн өмчлөгчийн шинэчлэл өөрчлөлтийг хийгээгүй;
- Компанийн харилцах дансыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн Албанаас битүүмжилсэн асуудал шийдээгүй, М.Ундралын ХААН банкны 5020836818 (MNT) харилцах дансаар гүйлгээ хийж буй нь харилцах дансны үлдэгдлийн баталгаажилт хангахгүй байна.
- Санхүүгийн тайланд тусгасан Мөнхзолбоотой холбоотой авлагын үлдэгдэл дүн 936,441.7 мянган төгрөг барагдаагүй, Шүүхийн шийдвэртэй холбоотой өр төлбөрийн асуудал болон холбоотой талын гүйлгээ тайлагнаагүй, 928,731.5 мянган төгрөг төсөвт төлөх татварын өглөг барагдуулаагүй байна.

Тайлант онд дараах зөрчлүүд байна.

1. Татвар,НДШ-ийн авлага барагдаагүй, дансны авлага 60.5 хувь буюу 3,468,080.8 мянган төгрөг, бусад авлага 7.1 хувь буюу 108,101.1 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.
2. Өмнөх оны дансны өглөг болон богино хугацаат зээлийн үлдэгдлүүд барагдаагүй, урьдчилж орсон орлого 2 дахин буюу 3,130,001.8 мянган төгрөг, бусад богино хугацаат өр төлбөр 1,477,155.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн.
3. Бараа материал, үндсэн хөрөнгийн тайлант үеийн үлдэгдлийн тооллого хийж, баталгаажилт хангаагүй.

4. Компанийн Нийт хөрөнгөөс өр төлбөрийн дүнг хасвал өөрийн хөрөнгийн дүн /16,868,216,945.70 -13,110,827,765.48/ 3,757,389,180.22 төгрөг буюу хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээс (2,743,110,819.78) төгрөгөөр өөрийн хөрөнгийн төлбөрийн чадвар буурсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх"; 12 дугаар зүйл 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 12.2.2. эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед; 12.2.3. эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед; 12.2.5. аж ахуйн нэгж, байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай шийдвэр гарсан, дампуурлын хэрэг үүсгэсэн үед; 12.2.6. хуульд заасан бусад тохиолдолд; 13 дугаар зүйлийн 13.1 Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно., 13.7 Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно., 20 дугаар зүйлийн 20.2.3 холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах; 20.2.5. дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, 20.2.6. эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; гэсэн заалтууд хэрэгжээгүй байгаа нь тасралтгүй үйл ажиллагаанд эрсдэл учирч болзошгүй нь санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, тохиолдсон байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитын ажлаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Бид засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй аудитын хамрах цар хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар компаниас ирүүлсэн баримт материалын хүрээнд илэрсэн дутагдал, зөрчлийн талаарх асуудлыг зөвлөмжөөр удирдлагад танилцуулан хүргүүлсэн болно.

Тайлангийн хэрэглээний хязгаарлалт

Энэхүү аудиторын тайланг Компанийн тухай хуулийн 94.1, 95.1 дүгээр зүйлүүдэд заасны дагуу компанийн удирдлага, хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн. Бид уг тайлангийн агуулгын хүрээнд аливаа нэг гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.



ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

УЛААНБААТАР ХОТ ЧД 2 ХОРОО

Огноо: 2026.04.06

Мерекс ХК

2025 оны санхүүгийн тайлангийн
бодит байдлын тухай мэдэгдэл

2025 оны 12 - р сарын 31-ны өдөр

Захирал Г.Чинхүсэл, нягтлан бодогч Б.Цэрэнханд бид манай аж ахуйн нэгжийн 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг " Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 9.1 дэх заалтын дагуу үнэн зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд :

1. Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн
3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засаг санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан
4. Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгаагүй, мөн тайлант оны ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй
5. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан
6. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

..... Г.ЧИНХҮСЭЛ

НЯГТЛАН БОДОГЧ

..... Б.ЦЭРЭНХАНД

УДИРДЛАГЫН ТӨЛӨӨЛЛИЙН ЗАХИДАЛ

Манай байгууллагын 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид санхүүгийн тайлангаа холбогдох санхүүгийн тайлагналын стандарт болон заавар журмын дагуу бэлтгэсэн талаар саналаа илэрхийлэх зорилгоор энэхүү захидлыг бичиж байна. Бид санхүүгийн тайлангаа холбогдох санхүүгийн тайлагналын стандарт болон заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй гэдгээ баталгаажуулж байна.

Энэ захидалд харуулсан зарим зүйлүүд нь материаллаг гэж үзэх боломжгүй байж болох юм. Учир нь бид санхүүгийн тайлангийн хэрэглэгчийн шийдвэрт нөлөө үзүүлэхүйц алдаа эсвэл буруу тайлагналыг материаллаг гэж үзсэн.

Бид 2026 оны 04 сарын 2-ний өдрийн байдлаар өөрсдийн мэдлэг, итгэл үнэмшлийн дагуу дараах зүйлүүдийг баталгаажуулж байна.

- Бид санхүүгийн тайлангуудыг холбогдох санхүүгийн тайлагналын стандарт, заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн.
- Бид санхүүгийн холбогдолтой бүх данс бүртгэл, тоо дүн, бүх шатны удирдлагын хурлын тэмдэглэл болон саяхан болсон боловч хараахан бэлтгэгдээгүй байгаа хурлын тэмдэглэл зэрэг бүх мэдээллээр хангасан.
- Санхүүгийн тайлагналтай холбоотой аливаа хууль бус үйл ажиллагаа явуулсан талаар холбогдох байгууллагаас мэдээлэл ирээгүй.
- Бүртгэл тайланд тусгагдаагүй аливаа материаллаг ажил гүйлгээ байхгүй.
- Удирдлага болон бусад гүйцэтгэх ажилтнуудтай холбоотой залилан эсвэл санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэх залилантай холбоотой нөхцөл байдал үүсээгүй.
- Холбоотой талуудын ажил гүйлгээ, бүх гол чухал тооцоолол, удирдлагаас тодруулах ёстой материаллаг шинжтэй бүх зүйлсийг санхүүгийн тайлангийн тодруулгын хэсэгт бүрэн тусгасан.
- Санхүүгийн тайланд тодруулагдах ёстой хууль зөрчсөн үйл ажиллагаа болон шүүхийн томоохон хэмжээний зарга маргаан, ирээдүй үеийн өр төлбөртэй холбоотой асуудал үүсээгүй.
- Байгууллага нь бүх хөрөнгийнхөө хувьд хууль ёсны эзэмшлийн гэрчилгээтэй бөгөөд хөрөнгийг хууль бусаар ашиглах гэх мэт үйл ажиллагаатай холбоотой зүйл гараагүй.
- Санхүүгийн тайланд материалагаар нөлөөлөх бүх гэрээ хэлэлцээрүүдийг бид дагаж мөрдсөн.
- Тайлагналын өдрийн дараах аливаа үйл явдал тохиолдоогүй бөгөөд энэхүү захидал бэлтгэсэн өдрийн байдлаар залруулга болон тодруулга шаардлагатай ажил гүйлгээ гараагүй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/ Г.Чинхүсэл /

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

/ Б.Цэрэнханд /

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

“Мерекс” ХК нь 2012 онд гадаад худалдаа, барилгын материалын худалдааны чиглэлээр анх үүсгэн байгуулагдсан байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2013 оны 12-р сард “Мерекс” ХХК-ийн нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх хүсэлтийг хэлэлцэж, 514 дүгээр тогтоолоор баталж, 2014 оны 1-р сард Монголын хөрөнгийн бирж компанийн үнэт цаасыг бүртгэж авснаар “Мерекс” хувьцаат компани болж 2014 оны 8 сард үйлдвэрээ бүрэн угсарч дуусаж 2015 оноос бетон зуурмагийн үйлдвэрлэлээ албан ёсоор эхлүүлсэн байна.

Мерекс ХК нь цагт 150 м3 бетон зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтай, TW-2500 маркийн дэвшилтэд төхөөрөмж бүхий БНСУ-д үйлдвэрлэгдсэн автоматжуулсан бетон зуурмагийн үйлдвэртэй. Мерекс бетон зуурмагийн үйлдвэр нь орон сууцны барилга, зам, нисэхийн зурвас болон бусад бүтээн байгуулалт, барилгажилтад ашиглагдах MNS1185-98 стандартыг хангасан M100-M600 хүртэлх маркийн бетон зуурмагийг үйлдвэрлэдэг.

Алсдаа бетон зуурмаг үйлдвэрлэж түгээхээс гадна нэмүү өртөг шингэсэн бетон хийцийн үйлдвэрлэлийг цогцоор нь хөгжүүлэх зорилготой ба өөрөө өөрийгөө түүхий эдээр хангах стратегийг баримтлан ажиллаж байна.

Тус үйлдвэр нь Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны Нутаг дэвсгэр дээр байрладаг.

2022 онд 10-11 үндсэн ба гэрээт ажилчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Компани нь Монгол Улсын Барилга, Хот Байгуулалтын Яамнаас Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авч ажиллаж байна.

№	Олгосон огноо	Т/З-ийн дугаар	Эрхлэх үйл ажиллагааны төрөл	Үйлчлэх хүрээ	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	2022-12-09	Дугаар МҮ18-048/22	Бетон зуурмаг үйлдвэрлэх	Орон нутаг, хот	5 жил

Мерекс ХК (цаашид “компани” гэх) нь Регистр 5631084, Улсын бүртгэлийн гэрчилгээ 9010001122 дугаартай 2 гишүүнтэй 6,500,500.0 мянган төгрөгийн өөрийн хөрөнгөтэй Данаасүрэн овогтой Батцэцэг, Мөнх-Эрдэнэ овогтой Ундрал нар анх үүсгэн байгуулсан байна. Гүйцэтгэх захирлаар 2013 оны 07 дугаар сараас Мөнхдулам овогтой Мөнхзолбоо ажилласан бөгөөд 2021 оны 03 дугаар сарын 15-ний өдрөөс ТУЗ-ийн 21/03/15/01 дугаар тогтоолоор ажлаас чөлөөлсөн байна Гэвч ажил үүргээ Мөнхдулам овогтой Мөнхзолбоо нь хүлээлгэн өгөөгүй ба түүнтэй холбоотой 892,199.0 мянган төгрөгийн авлага шийдвэрлээгүй байна.

Компани нь үйл ажиллагаа явуулах үүднээс 2021 оны 04 дүгээр сарын 15-ний өдрийн ТУЗ-ийн 21/04/15/01 дугаар тогтоолоор Г.Манлайбаярыг гүйцэтгэх захирлаар түр орлон гүйцэтгэгчээр 2023 оны 07 дугаар сарын 20 –ний өдөр хүртэл ажиллаж байсан байна. 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрөөс ТУЗ-ын 1623//2 тогтоолоор М. Ундралыг гүйцэтгэх захирал түр орлон гүйцэтгэгчээр томилогдсон байна.

Үүний дагуу компанийн дүрэм, гүйцэтгэх удирдлагыг Улсын бүртгэлийн гэрчилгээнд шинэчлэл өөрчлөлтийг хийгээгүй ба 2025 оноос Г.Чинхүсэлийг гүйцэтгэх захирал томилсон байна.

Тус аудитын ажлыг компанийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон холбогдох М.Ундралын ХААН банкны 5020836818 (MNT) харилцах данс болон ерөнхий журнал, гүйлгээ баланс, аудитын асуулга, компанийн ирүүлсэн бичиг баримтын хүрээнд тус аудитын компанийн захирал аудитор Ж.Бямбажав, аудитор Б.Цэвэлмаа бид нар 2026 оны 02 дугаар сарын 25-ний өдрөөс 04 дүгээр сарын 02-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Компанийн эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл

№	Овог Нэр	Албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны хувь
1	М.Ундрах	Гүйцэтгэх захирал 2023 оны 08 сарын 01-нээс	12 %
2	Б.Цэрэнханд	Нягтлан бодох /гэрээт/	0 %

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Овог Нэр	Гишүүнчлэл	Эзэмшиж буй хувьцааны хувь
1	Г. Бямбабаяр	ТУЗ-ийн дарга	42,46 %
2	Л. Чулуунбаатар	ТУЗ-ийн гишүүн	0 %
3	М. Ундрал	ТУЗ-ийн гишүүн	12 %
4	Э.Эрдэнэсүх	ТУЗ-ийн гишүүн	0 %

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

№	Овог Нэр	Эзэмшиж буй хувьцааны хувь	Бусад компанийн хувьцааг эзэмшиж буй байдал	Түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд
1	STANDARD INVESTMENT	27.07 %	Байхгүй	Байхгүй
2	MONGOLIA CAPITAL AG	8.48 %	Байхгүй	Байхгүй
3	МӨНХ-ЭРДЭНЭ	12 %	Байхгүй	Байхгүй

№	Овог Нэр	Эзэмшиж буй хувьцааны хувь	Бусад компанийн хувьцааг эзэмшиж буй байдал	Түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд
	УНДРАЛ			
4	ГОМБОЖАВ БЯМБАБАЯР	42.46 %	Байхгүй	Байхгүй

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТҮҮХ

№	Овог Нэр	Эзэмшиж байсан хувьцааны хувь	Эзэмшиж байсан огноо
1	РИЙЧ ШЕЛ ХХК	16.3 %	2018-07-31
2	ВОРЛДФРЕНДС ХХК	28 %	2018-07-31

Мерекс ХК нь 65,005,000 ширхэг хувьцаанд 439 хувьцаа эзэмшигч бүртгэлтэй байна

Компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээнд гүйцэтгэх удирдлага томилсон тушаалын болон компанийн эцсийн өмчлөгчийн бүртгэлийн шинэчлэл хийгээгүй байна.

Үүнтэй уялдан компанийн удирдлага болон хувьцаа эзэмшигчид нар өөрчлөгдсөнтэй холбоотой компанийн дүрмийг шинэчлэн баталгаажуулах шаардлагатай байна.

Тус компанийн 2024 оны санхүүгийн үзүүлэлтийг товч харуулбал:

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ /мянган төгрөг/

- Нийт хөрөнгө-16,868,216,945.70₮
- Өр төлбөрийн нийт дүн- 13,110,827,765.48₮
- Эзэмшигчдийн өмчийн дүн-6,500,500,000.00₮
- Нийт гаргасан хувьцаа-65,005,000ш

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ/мянган төгрөг/

- Нийт борлуулалтын орлого- 1,695,810,888.89 ₮
- Борлуулсан бүтээгдэхүүний өртөг-725,356,363.09₮
- Хуримтлагдсан ашиг/ алдагдал--(2,743,110,819.78₮)
- Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал- 355,948.17₮

- Нэгж хувьцааны дансны үнэ-100₮

Тус компани тайлант үед ашигтай ажилласан боловч санхүүгийн тайлангийн хуримлагдсан ашиг, өөрийн хөрөнгийн төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

01. САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ, СУУРЬ

Тус компани нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 361 дугаар "Маягт заавар батлах тухай" тушаалын Аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" 1 дүгээр, "Санхүүгийн тайлангийн А маягт"-ыг 2 дугаар хавсралтуудыг үндэслэн бэлтгэсэн.

Компанийн хувьцаа эзэмшигчид компанийн өр төлбөрийг барагдуулах хангалттай мөнгөн хөрөнгөтэй байлгахыг хүлээн зөвшөөрдөг учраас компани санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэдэг.

Компани нь цаашид компанийн үйл ажиллагаа тасралтгүй үргэлжилнэ гэсэн төсөөлөл дээр санхүүгийн тайланг бэлтгэсэн хэдий ч өөрийн хөрөнгийн төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай байна..

Санхүүгийн тайлан бэлтгэх үндсэн зарчим

Компани санхүүгийн тайлангаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (цаашид СТОУС гэх), Олон улсын санхүүгийн тайлагналын стандартын Тайлбарын байнгын хорооноос баталсан тайлбар, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж болон Сангийн яамнаас баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт, дансны үлгэрчилсэн заавар", "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэж, гаргах аргачлал"-ын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан бэлтгэдэг.

Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг бэлтгэсэн валют

Компанийн үйл ажиллагааны үндсэн валют нь Монгол Улсын мөнгөн тэмдэгт "төгрөг" юм. Хавсаргасан санхүүгийн тайланг төгрөгөөр бэлтгэсэн.

02. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОНЦЛОХ БОДЛОГУУД

1. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө ба банкин дахь харилцах данстуудаас бүрддэг. Мөнгөн хөрөнгийг банканд байлгах нь ямар нэг эрсдэл агуулахгүй. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Гадаад валютаарх мөнгөн хөрөнгийг Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлж бүртгэдэг.

2. Борлуулалтын ба бусад авлагууд

Борлуулалтын болон бусад авлагуудыг анх бүртгэхдээ нэрлэсэн үнээр нь бүртгэх бөгөөд найдваргүй авлагыг бүртгэх шууд данснаас хасах аргын дагуу авлагыг найдваргүй нь нотлогдсон үед найдваргүй авлагын зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэх ба найдваргүй болсон авлагын дүнгээр дансны авлагыг бууруулна.

3. Бараа материал

Компанийн бараа материалд бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад худалдан борлуулахаар эзэмшиж байгаа хөрөнгө, эсвэл үйлчилгээ үзүүлэхэд ашиглах гэж байгаа материал болон хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа хөрөнгө орно.

Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбоотой гарсан зардал орно. Худалдан авалтын өртөг нь худалдан авсан үнэ, гаалийн татвар, хураамж, тээврийн зардал, бусад холбогдох зардлуудаас бүрдэнэ.

Цэвэр боломжит үнэ цэнэ нь байгууллагын тодорхойлсон үнэ байдаг бол бодит үнэ цэнэ нь холбоогүй талуудын ажил гүйлгээгээр зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хооронд хөрөнгийг солилцох, эсвэл өр төлбөрөөр тооцож болох дүн юм.

4. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь худалдаж авсан үнэ, импортын татвар, нөхөн олгохгүй худалдан авалтын бусад татварууд болон хөрөнгийг байршуулах, зориулалтаар нь ашиглахад бэлэн болгохтой шууд холбоотой гарах зардлаас бүрддэг. Үндсэн хөрөнгийг ашиглалтад оруулснаас хойш гарсан зардлуудыг тухайлбал засвар үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан жилийн үр дүнгийн тайланд тусгадаг. Харин тухайн зардал гарснаар хөрөнгийг анх авах үеийн тооцоолсон бүтээмж нэмэгдэж, хөрөнгөөс олох эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг нэмэгдүүлсэн нь тодорхой батлагдаж байвал гарсан зардлыг хөрөнгийн өртөг дээр нэмж капиталжуулна. Үндсэн хөрөнгийн үнэ цэнийг тогтмол хянаж, НББОУС-16-ын дагуу дансны үнэ, балансын өдрөөрх бодит үнэ цэний хооронд материаллаг зөрүү гарсан нөхцөлд дахин үнэлгээ хийдэг.

Дахин үнэлгээний нэмэгдлийг дахин үнэлгээний нөөц дансанд тусгана. Харин дахин үнэлгээний бууралтыг тухайн хөрөнгийн хувьд үүссэн өмнөх жилийн нэмэгдлийн дүнг тэг болтол дахин үнэлгээний нөөц дансыг бууруулна. Бусад бүх тохиолдолд дансны үнийн бууралтыг орлогын тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тухайн хөрөнгийг ашиглах боломжтой болсон үеэс эхэлж байгуулдаг ба стандартын дагуу шулуун шугамын арга, үлдэгдлийг буруулах арга, бүтээгдэхүүний нэгжийн аргуудаас ашиглаж болох хэдий ч Монгол улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу шулуун шугамын аргаар элэгдэл тооцож байгуулдаг, үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацаа дараах байдалтай байна.

№	Үндсэн хөрөнгийн бүлэг	Татварын хуулиар	Компанийн хувьд
		Ашиглах хугацаа (жилээр)	Ашиглах хугацаа (жилээр)
1.	Барилга, байгууламж	25	25
2.	Машин, механизм, техник, тоног төхөөрөмж	10	10
3.	Компьютер, түүний эд анги, программ хангамж	2	2
4.	Бусад үндсэн хөрөнгө	10	10

Үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа үлдэгдэл өртгийн дүнгээр хөрөнгө данснаас хассаны гарзыг, худалдан борлуулах үед хөрөнгийн үлдэгдэл өртөг, худалдсан үнийн зөрүүгээр хөрөнгө худалдан борлуулсны олз, гарзыг хүлээн зөвшөөрдөг.

5. Дансны ба бусад өглөг

Дансны болон бусад өглөгийг анх бүртгэхдээ нэрлэсэн үнээр нь бүртгэдэг бөгөөд дараагийн тайлант хугацаа бүрд хөнгөлөлт нь материаллаг биш бол өртөг болж, өглөгийг хорогдуулан бүртгэнэ.

6. Хувьцаат капитал

Энгийн хувьцаа

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөөр ангилна. Энгийн хувьцаа гаргахтай шууд холбоотой гарсан зардлуудыг татварыг нь суутгасан цэвэр дүнгээр өөрийн хөрөнгийг бууруулан бүртгэдэг. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу компанийн хувьцаа нь компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг хувьцаа эзэмшигчийн эрхийг гэрчилнэ.

Халаасны хувьцаа

Өөрийн хөрөнгөөр бүртгэсэн энгийн хувьцааг эргүүлэн худалдан авахдаа төлсөн, ийнхүү худалдан авахтай холбоотой гарсан бүх зардлуудыг, татварыг нь хассан цэвэр дүнгээр өөрийн хөрөнгийг бууруулан бүртгэдэг. Эргүүлэн худалдан авсан хувьцааг халаасны хувьцаагаар ангилах ба нийт өөрийн хөрөнгийн бууралт байдлаар харуулдаг. Харин халаасны хувьцааг дахин гаргасан, худалдсан бол хүлээн авсан мөнгөн дүнгээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх ба тухайн гүйлгээнээс бий болсон илүү ба дутуугийн зөрүүг хуримтлагдсан ашгаас нөхөх эсвэл ашгийг нэмэгдүүлэх байдлаар залруулдаг.

7. Орлого хүлээн зөвшөөрөх

Орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Орлогод зөвхөн тухайн бизнесийн үйл ажиллагаанаас хүлээн авсан болоод ирээдүйд хүлээн авах эдийн засгийн өгөөжийн дотогш урсгал хамаарна. Суутгасан татвар, барааны болон үйлчилгээний хураамж, нэмэгдсэн өртгийн татвар зэрэг гуравдагч талын өмнөөс цуглуулсан дүн нь аж ахуйн нэгжийн эдийн засгийн өгөөжид хамаарахгүй бөгөөд эзэмшигчдийн өмчийг нэмэгдүүлэхгүй. Иймээс эдгээрийг орлогын дүнгээс хасаж тооцдог.

Компани тайлант хугацаанд үйлдвэрлэж, хэрэглэгчдээс нэхэмжилсэн барааны үнийг борлуулалтын орлогод бүртгэдэг бөгөөд борлуулалтын орлогыг хүлээн авсан буюу хүлээн авахаар хүлээгдэж буй мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн нэрлэсэн үнээр хэмжиж, тайлагнадаг.

Гадаад валютын хөрвүүлэлт

Санхүүгийн тайланг төгрөгөөр илэрхийлсэн бөгөөд компани үйл ажиллагаагаа явуулдаг албан ёсны мөнгөн тэмдэгт нь Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөг юм. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн валютаар болон гүйлгээ хийгдэх үеийн Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлэн, төгрөг/валютаар давхар бүртгэдэг. Гадаад валютаарх мөнгөн хөрөнгө, тооцооны данстыг балансын дуусгавар болсон өдрийн албан ханшаар төгрөгт шилжүүлэн бүртгэсэн. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээнээс үүссэн зөрүүг орлогын тайланд тусгагддаг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг түүхэн өртгөөр нь тооцож, тухайн ажил гүйлгээ анх гарсан өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг бөгөөд нэрлэсэн үнийг тогтоосон өдрийн ханшаар хөрвүүлэн балансаа тусгадаг.

8. Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж

Ажилчдын богино хугацааны тэтгэмжид цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, ээлжийн амралтын цалин, өвчтэй хугацааны тэтгэмж, арван хоёр сарын дотор төлөгдөх ашгийн хуваарилах, шагналын өглөг болон мөнгөн бус тэтгэмжүүд болох эмнэлгийн үйлчилгээ, байрны хөлс, унааны хөлс, үнэгүй буюу хөнгөлөлттэй бараа үйлчилгээ ордог.

9. Орлогын албан татвар

Тайлант үеийн татвар гэдэгт тайлант үеийн татвар ногдуулах ашиг (алдагдал)-аас тооцсон орлогын албан татварын өглөгийн дүн болон хойшлогдсон татварын өглөг эсвэл хойшлогдсон татварын хөрөнгөөс бүрддэг. Тайлант жилийн татвар нь тухайн жилийн орлогоос хуулийн дагуу тогтоосон татварын хувиар ногдуулсан татварын өглөгийн дүн юм.

Хойшлогдсон татварын хөрөнгө болон татварын өглөг нь санхүүгийн байдлын тайлан дахь хөрөнгө, эсвэл өр төлбөрийн дансны үнэ ба татварын суурь хоёрын хоорондох зөрүүнээс үүсдэг. Түр зөрүү нь хоёр хэлбэртэй бөгөөд эдгээр нь зэрэг тодорхойлогддоггүй, аль нэг нь л байна. Үүнд:

- *татвар ногдох түр зөрүү* гэдэг нь хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны үнийг нөхөх эсвэл барагдуулах үед ирээдүйн тайлант үеийн татвар ногдуулах ашиг (татварын алдагдал)-ыг тодорхойлоход татвар ногдох орлогод үүсэх түр зөрүү юм.
- *хасагдах түр зөрүү* гэдэг нь хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны үнийг нөхөх эсвэл барагдуулах үед ирээдүйн татвар ногдуулах ашиг (татварын алдагдал)-ыг тодорхойлоход татвар ногдох орлогоос хасагдах дүнгээс үүсэх түр зөрүү юм.

03. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ БА ТООЦООЛОЛ

Компанийн удирдлага санхүүгийн тайлан бэлтгэхэд тайлант үеийн орлого, зардал, хөрөнгө болон өр төлбөрүүдэд нөлөөлөхүйц үнэлгээ, тооцоолол, таамаглалыг боловсруулах шаардлагатай тулгардаг. Эдгээр таамаг тооцооны эргэлзээтэй дүнг ирээдүйн хөрөнгө ба өр төлбөрт нөлөөлөхүйц материаллаг бол тохируулах бичилт хийдэг.

а) Тооцооллын эх үүсвэр

Санхүүгийн тайлангийн өдрөөрх ирээдүйн үйл ажиллагааны тухай авч үзэж байгаа гол тооцоолол болон эргэлзээтэй тооцооллын эх үүсвэр нь дараагийн тайлант жилд уг хөрөнгийн дүнд материаллаг тохируулах бичилт хийх эрсдэл бий болоход нөлөөлдөг. Ирээдүйд нөлөөлж болох тооцооллыг доор тайлбарлав.

Барилга, тоног төхөөрөмжийн элэгдэл

Барилга, тоног төхөөрөмжийг тэдгээрийн ашиглалтын хугацаанд үндэслэн шулуун шугамын аргаар элэгдүүлдэг. Барилга, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу 10-аас 40 жилийн хооронд байна гэж удирдлага үздэг. Ашиглах хугацаа, технологийн дэвшлээс үүдэн тооцоолсон ашиглах хугацааны өөрчлөлт нь ашиглах хугацааны хэмнэлт болон эдгээр хөрөнгийн үлдэх өртөгт нөлөөлдөг тул дараагийн жилүүдийн элэгдлийн зардлыг дахин хянах шаардлагатай байдаг.

Хөрөнгийн үнэ цэний бууралт

Компани нь хөрөнгийн үнэ цэнэ буурч болзошгүй болохыг илтгэх шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлэх хэрэгтэй. Хэрэв ийм ямар нэг шинж тэмдэг илэрвэл компани хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолох ёстой. Нөхөгдөх дүн нь хөрөнгө эсвэл хөрөнгө бий болгогч нэгжийн бууруулах зардлыг хассан бодит үнэ цэнэ ба ашиглалтын үнэ цэний аль их нь байна.

б) Хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрөх

